



ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО,
ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН ДАРГЫН
ТУШААЛ

2026 оны 01 сарын 07 өдөр

Дугаар А/2

Улаанбаатар хот

Ажлын хэсэг байгуулах тухай

Засгийн газрын агентлагийн эрх зүйн байдлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.4, Монгол Улсын Засгийн газрын 2025 оны “Хойд бүсийн хөгжлийг эрчимжүүлэх зарим арга хэмжээний тухай” 204 дүгээр тогтоолын 1.3.3 дахь заалт, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2025 оны “Үндсэн хөрөнгө шилжүүлэх зөвшөөрөл олгох тухай” 744 дүгээр тогтоолыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1.Хойд бүсийн хавдрын оношилгоо, эмчилгээний дэд төв болгон хөгжүүлэх зорилгоор “Эрдэнэт үйлдвэр” төрийн өмчит үйлдвэрийн газрын харьяа “Эрдэнэт медикал” төрөлжсөн мэргэшлийн эмнэлгийн үндсэн хөрөнгийг Хавдар судлалын үндэсний төвд шилжүүлэх шийдвэр гарсантай холбогдуулан хөрөнгө хүлээлцэх үүрэг бүхий Ажлын хэсгийг 1 дүгээр хавсралтаар байгуулсугай.

2.Ажлын хэсгийн ажиллах удирдамжийг 2 дугаар хавсралтаар баталсугай.

3.Албан томилолтын зардлын төсвийг гуравдугаар хавсралтаар баталж, хавсралтад заасны дагуу холбогдох эх үүсвэрээс гаргаж зарцуулахыг Ерөнхий нягтлан бодогч (Д.Отгонтуяа)-д зөвшөөрсүгэй.


ДАРГА



Б.ЦЭНГЭЛ

132003387

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын
даргын 2026 оны 01 дүгээр сарын 07-ны өдрийн
дугаар тушаалын 1 дүгээр хавсралт



АЖЛЫН ХЭСГИЙН БҮРЭЛДЭХҮҮН

Ахлагч:	Д.Нарангэрэл	/Төрийн өмчийн бүртгэл, ашиглалтын хэлтсийн дарга/
Гишүүд:	Ө.Саранцэцэг	/Хууль, эрхзүйн хэлтсийн ахлах мэргэжилтэн/
	М.Баярмаа	/Төрийн өмчийн бүртгэл, ашиглалтын хэлтсийн мэргэжилтэн/
Жолооч:	Б.Энхбаяр	/ТӨБЗГ-ын жолооч/

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын
даргын 2026 оны 01 дүгээр сарын 07-ны өдрийн
А/а дугаар тушаалын 2 дугаар хавсралт

АЖЛЫН ХЭСГИЙН АЖИЛЛАХ УДИРДАМЖ

Нэг: Зорилго. Монгол Улсын Засгийн газрын 2025 оны 204 дүгээр тогтоолын 1.3.3-т заасны дагуу “Эрдэнэт үйлдвэр” төрийн өмчит үйлдвэрийн газрын харьяа “Эрдэнэт медиал” төрөлжсөн мэргэшлийн эмнэлгийг Хавдар судлалын үндэсний төвд шилжүүлэх ажлын хүрээнд Ажлын хэсэг энэхүү удирдамжийг баримтална.

Хоёр: Хийгдэх ажлын чиглэл.

1.Төрөлжсөн мэргэшлийн эмнэлгийн үндсэн хөрөнгөд бүртгэлтэй үл хөдлөх болон хөдлөх хөрөнгийг хүлээлцэж, санхүүгийн тайлантай тулган баталгаажуулалт хийх, акт үйлдэх, хөрөнгө хүлээн авах эрх хүлээн авагчид шилжүүлэх ажлыг зохион байгуулах;

2.Төсвийн болон бусад өр төлбөр, ажиллагсадтай хийх өр, авлагын тооцоог хийж актаар баталгаажуулах;

3.Орон тоог шилжүүлэн авах, тэдгээртэй холбоотой санхүүгийн тооцоо гаргах, цалин, хөлс, нийгмийн даатгалыг тасалдуулахгүй байх арга хэмжээ авч ажиллахад дэмжлэг үзүүлэх, ажилтнуудын нийгмийн баталгаа, эрх зүйн байдлыг дордуулахгүй байх арга хэмжээ авахад мэргэжил арга үйн туслалцаа үзүүлэх;

4. Төрөлжсөн мэргэшлийн эмнэлгийн дуусаагүй худалдан авалт, гэрээгээр хүлээсэн эрх, үүрэг, судалгаа шинжилгээний бүтээл зэргийн эрхийг холбогдох хууль журмын дагуу хүлээлцэх;

6.Архив, албан хэргийн материалыг акт үйлдэн эрх хүлээн авагчид шилжүүлэн өгөх;

7.Санхүүгийн хаалтын тайлан тэнцэл гаргах;

----- о о о -----

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын
2026 оны 01 дугаар сарын 07-ны өдрийн
А/К дугаар тушаалын 3 дугаар хавсралт

ОРОН НУТАГТ ТОМИЛОЛТООР АЖИЛЛАХ
ЗАРДЛЫН ТӨСӨВ

Хойд бүсийн хавдрын оношилгоо, эмчилгээний дэд төв болгон хөгжүүлэх зорилгоор “Эрдэнэт үйлдвэр” төрийн өмчит үйлдвэрийн газрын харьяа “Эрдэнэт медиал” төрөлжсөн мэргэшлийн эмнэлгийн үндсэн хөрөнгийг Хавдар судлалын үндэсний төвд шилжүүлэх шийдвэр гарсантай холбогдуулан хөрөнгө хүлээлцэх мэргэжил арга зүйгээр хангах албан ажлаар Ажлын хэсгийн албан томилолтын зардлын төсөв.

Хугацаа: 2026 оны 01 дүгээр сарын 08-ны өдрөөс 01 дүгээр сарын 10-ны өдрүүдэд /хуанлийн 3 хоногоор/ хийж гүйцэтгэнэ.

Д/д	Зардлын төрөл	Төсөвлөсөн /төгрөгөөр/
1	Орхон аймаг: Унаа: $800 \text{ км} \times 2920 \times 0.18 = 420,480.00$ Буудал: $4 \text{ хүн} \times 150,000 \times 2 \text{ хоног} = 1,200,000.00$ Хоол: $4 \text{ хүн} \times 50,000 \times 3 \text{ хоног} = 600,000.00$	2,220,480.00
	Нийт дүн:	2,220,480.00

Тайлбар: Дотоод томилолтын зардлыг тооцохдоо Сангийн сайдын 2024 оны 04 дугаар сарын 01-ний өдрийн А/52 дугаар тушаалаар баталсан “Дотоод албан томилолтын зардлын хэмжээг шинэчлэн батлах тухай” тушаалыг үндэслэв.

Хянасан:

Боловсруулсан:

Н.Ганболд /Захиргаа удирдлагын хэлтсийн дарга/

Д.Отгонтуяа /Ерөнхий нягтлан бодогч/

М.Баярмаа /ТӨБАХ-ийн мэргэжилтэн/